

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛЭЭС

АЙМАГ, НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАРТ

Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 09 дүгээр сарын 13-ны өдрийн хуралдааны 37 дугаар тэмдэглэлд:

“XV.2.Шинэ сэргэлтийн бодлогын хүрээнд хэрэгжүүлж байгаа төрийн өмчит компаниудын сэргэлтийн ажлын явцын талаар Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Д.Амарбаясгалан Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан:

1.Төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн нэгжүүдийн үр ашиг, засаглалыг сайжруулж, олон нийтийн шууд хяналтад оруулах ажлыг зохион байгуулах хүрээнд дараахь 6 чиглэлийг баримтлах нь зүйтэй гэж үзэв:

-Төрийн өмчит хуулийн этгээдүүдийг нэгтгэх, нийлүүлэх, компанийн хэлбэрт шилжүүлэх;

-Төрийн өмчит компаниудын хувьцааг хөрөнгийн зах зээлд (IPO) гаргах замаар нээлттэй, ил тод байдлыг хангах;

-Төрийн өмчийн удирдлагын компани байгуулах замаар нэгдсэн удирдлагаар хангах;


-Төрийн өмчит хуулийн этгээдүүдийн ажилтнуудын тоог зохистой түвшинд байлгах;

-Хувьцаа эзэмшигчээс тавих шаардлага, хяналт, үнэлгээг дээшлүүлэх;

-Төрийн өмчит компаниудыг инновац, ногоон технологид суурилсан байдлаар өөрчлөх, хөгжүүлэх.

2.Төрийн болон орон нутгийн өмчит компанийн үйл ажиллагаа, засаглалыг сайжруулах, үр ашиг, өгөөжийг нэмэгдүүлэх, зардлыг бууруулах, хэмнэхэд чиглэсэн доор дурдсан арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Засгийн газрын холбогдох гишүүн, албан тушаалтанд даалгав:


2.1.Эрхлэх асуудлын хүрээ, салбарын хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа чиг үүргийн давхардал, хийдэл, зөрчилтэй, орлого, зардлын зохистой харьцаа алдагдсан, орон тоо, бүтцийн хувьд оновчгүй төрийн өмчит хуулийн этгээдүүдийг нэгтгэх, нийлүүлэх, татан буулгах замаар өөрчлөн зохион байгуулах саналаа шуурхай шийдвэрлүүлж ажиллахыг Сангийн сайд, Б.Жавхлан, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Б.Бат-Эрдэнэ, Зам, тээврийн хөгжлийн сайд С.Бямбацогт, Эрчим хүчний сайд Б.Чойжилсүрэн нарт;



2.2.Төрийн өмчит компаниудыг нэгдсэн удирдлага, зохион байгуулалт, уялдаа зохицуулалтаар хангах үүрэг бүхий төрийн өмчийн корпораци байгуулах талаар болон Сингапур Улсын (ТЭМАСЕК) байгууллагын туршлагыг нэвтрүүлэх, хамтран ажиллах чиглэлээр зохих арга хэмжээ авахыг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Д.Амарбаясгаланд;

2.3.Төрийн өмчит компаниудын хувьцааг биржээр олон нийтэд нээлттэй худалдах, нээлттэй хувьцаат компани болгох арга хэмжээний хэрэгжилтийг эрчимжүүлж, шаардлагатай бол холбогдох хууль тогтоомжид өөрчлөлт оруулах талаар саналаа танилцуулахыг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Д.Амарбаясгалан, Сангийн сайд Б.Жавхлан, Зам, тээврийн хөгжлийн сайд С.Бямбацогт, Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учрал нарт;

2.4.Орон нутгийн өмчит хуулийн этгээдийг нэгтгэх, нийлүүлэх, татан буулгах замаар өөрчлөн зохион байгуулах, нэгдсэн зохион байгуулалтад оруулах асуудлаар тодорхой санал боловсруулан танилцуулах, шийдвэрлүүлэх арга хэмжээ авч ажиллахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт, хэрэгжилтэд хяналт тавихыг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Д.Амарбаясгаланд.” гэжээ.



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

